



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 157

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах,
үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн 2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1, 7.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах" МОН9189 төслийн үйл ажиллагаа дуусгавар болж төслийн нэгжийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 5 нэрийн, нийт 18,612,000.00 (арван найман сая зургаан зуун арван хоёр мянга) төгрөгийн балансын үнэ бүхий, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглаж болох хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, үнийг нийт 6,204,000.00 (зургаан сая хоёр зуун дөрвөн мянга) төгрөгөөр хавсралтад заасны дагуу шинэчлэн тогтоохыг зөвшөөрсүгэй.

2. Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга Д.Ганболд, "Гэр хорооллын ариун цэврийн байгууламжийг сайжруулах замаар хөрсний бохирдлыг бууруулах" төслийн менежер Ж.Чойхандад дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасны дагуу хөрөнгийн ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА


Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА *Д. Нарангэрэл*

Д.НАРАНГЭРЭЛ



Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн
11 дугаар тогтоолын хавсралт



**ГЭР ХОРООЛЛЫН АРИУН ЦЭВРИЙН БАЙГУУЛАМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗАМААР ХӨРСНИЙ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ
ТӨСЛИЙН НЭГЖИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ ҮЛДЭХ ӨРТӨГГҮЙ АШИГЛАХ ХУГАЦАА СУНГАЖ, ҮНИЙГ ШИНЭЧЛЭН
ТОГТООХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Дахин үнэлгээ (нэг бүрийн үнэ)	Шинэчлэн тогтоох үнэ (төгрөг)	Цаашид ашиглах жил
1	Тог баригч APC BX800LI-MS	2017.06.01	2	497,200.00	82,867.00	165,734.00	1
2	Зөөврийн компьютер Apple Macbook Pro	2017.06.01	1	6,589,000.00	2,196,333.00	2,196,333.00	1
3	Зөөврийн компьютер Lenovo	2017.06.01	1	3,319,800.00	1,106,600.00	1,106,600.00	1
4	Зөөврийн компьютер Dell	2017.06.01	2	4,224,000.00	704,000.00	1,408,000.00	1
5	Зөөврийн компьютер HP	2017.06.01	1	3,982,000.00	1,327,333.00	1,327,333.00	1
Нийт дүн				18,612,000.00	5,417,133.00	6,204,000.00	